

**МОНГОЛ УЛС, ДЭЛХИЙН БАНКНЫ ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ,  
ХӨГЖЛИЙН БАНК БОЛОН ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ  
ХООРОНДЫН "МОНГОЛ УЛСЫН ТЭЭВРИЙН ХОЛБОЛТ БОЛОН  
ЛОГИСТИКИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ"-ИЙН ЗЭЭЛИЙН  
ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦСӨН ТАЛААРХ  
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 12 дугаар  
сарын 27-ны өдөр

Улаанбаатар  
хот

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцэхеэр ирүүлсэн Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хэлэлцлээ.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар дээрх төслийн зөвшилцех асуудлыг хэлэлцэн тухай санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд тус тус ирүүлсэн болно.

Тус Байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 19, 27-ны өдрийн хуралдаанаар дээрх төслийг хэлэлцлээ.

Байнгын хороо Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооноос ирүүлсэн санал, дүгнэлтийг гишүүдэд танилцуулсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаа, Х.Булгантуяа, Б.Баттөмөр, Э.Бат-Амгалан, Б.Бат-Эрдэнэ, Д.Бат-Эрдэнэ, Д.Ганбат, Д.Цогтбаатар нар шинээр тавигдах замын маршрут нь улсын хөгжлийн зорилттой нийцэж байгаа эсэх, логистикийн төвийг байгуулах аймаг, орон нутаг нь газар зүйн байршлын хувьд хэр оновчтой болох, зээл нь улсын ерийн нийт хэмжээнд хэрхэн нелөөлөх, логистикийн төвүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулах боломжтой эсэх, гадаадын зээл, тусlamжаар болон улсын төсвийн хөренгөөр хийгдэж байгаа замын өргтийн талаар тодруулж асуусан бөгөөд зээлийн хэлэлцээрийн төсөлд туссан зарим ажлууд ач холбогдол бага, үр ашиггүй байгааг анхааруулсан болно.

Түүнчлэн төслийн тодорхой хэсгийг эрчимжсэн мал аж ахуй хөгжсэн Сэлэнгэ, Төв аймгийн бүс нутагт хэрэгжүүлэх, мөн гадаадын зээл, тусlamжийн хөренгөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудын ерөнхий нөхцөл, зорилго, чиглэлийг цаашид илүү тодорхой болгоход онцгой анхаарах нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж логистикийн төв байгуулахад зарцуулах санхүүжилтийг зам засварын ажилд зарцуулах нь зүйтэй гэсэн санал гаргасан болно.

Хуралдаанд оролцсон Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун энэ зээлийн төсөл нь тус яамны баримталж буй бодлоготой нийцэхгүй байгаа тул дэмжих боломжгүй гэсэн саналыг Зам, тээвэр хөгжлийн яам болон Засгийн газарт өгсөн. Тухайлбал, баруун найман аймгийг холбосон логистикийн төв, махны үйлдвэрийг 28 сая ам.доллараар Өвөрхангай

аймагт байгуулахаар тесөлд тусгажээ. Үүнийг хувийн хэвшил аваад явж чадахгүй, төрд өр нэмнэ. Төр үйлдвэр авч явна гэж байхгүй.

Тус яамнаас баруун гурван аймгийг эрүүл бүс болгож, махыг нь экспортлох ажлыг хавраас хийж эхэлнэ. Гэтэл манай яамны бодлоготой нийцүүлэхгүйгээр Дэлхийн банкны зээлийг зүтгүүлээд байна. Бариад авах төсөл алга, логистикийн төв байгуулах зураг төсөл нь ч байхгүй. Энэ бол Дэлхийн банкны мөнгө биш, монголын өр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам энэ төслийн 30 сая амдолларын зээлээс татгалзаж байна гэсэн бөгөөд Байнгын хорооны хуралдаанд Х.Болорчулуун сайдын хэлсэн үг, илэрхийлсэн байр сууринаас үүдэн Зам, тээвэр хөгжлийн сайд С.Бямбацогт нарнын хооронд маргаан үүсч, хуралдааныг хойшшуулсан болно.

Тус Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан Засгийн газрын гишүүд саналаа нэгтгэхгүйгээр Улсын Их Хуралд асуудлыг өргөн мэдүүлж, Байнгын хорооны хуралдаанд Засгийн газрын ирүүлсэн төслөөс өөр, өөрсдийн хувийн байр суурийг илэрхийлэн маргалдаж байгаа нь Засгийн газрын нэр хүндийг унагааж, улмаар танхимын зарчмыг алдагдуулж байна гэв.

Түүнчлэн тэдний гаргасан энэ үйлдлээс шалтгаалж уг асуудлыг Байнгын хороо хоёр удаа хэлэлцэж байгааг Зам, тээвэр хөгжлийн болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нарт анхаарууллаа.

Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан энэ зээлийн хөтөлбөрийн төслийг сайжруулах талаар Засгийн газраас анхаарч, дараах чиглэлийн дагуу засаж сайжруулах нь зүйтэй гэсэн чиглэлийг Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан саналуудыг нэгтгэн өгсөн болно:

1.Энэ төсөл нь тээвэр логистикийн дэд бүтцийн сүлжээг сайжруулан, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлтийн сүлжээний алдагдлыг бууруулж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэнэ гэсэн боловч эдийн засгийн үр ашгийн шалгуур, тооцоо, судалгаа, үнэлгээг нарийвчлан гаргаж ирүүлээгүй байгааг анхаарах;

2.Эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс шинэчлэх, засвар хийх улсын чанартай 311 км авто замын 1 км замын болон засвар хийх 8 бетон гүүрийн үнэ, ертгийг нарийвчлан тооцож гаргах, авто замыг олон улсын болон бүсийн тээвэр логистикийн нэгдсэн сүлжээ, баруун болон зүүн босоо тэнхлэгийн авто зам, хөрш орнуудын сүлжээтэй холбоход анхаарах;

3.Жишиг логистикийн төвийг байгуулах, боомтын нэвтрэх чадварыг сайжруулах, гадаад худалдааг нэмэгдүүлэх ажлын хүрээнд авто машины жин хэмжүүр, ариутгалын болон холбогдох тоног төхөөрөмжийг шинэчлэх, сайжруулах ажлыг цогц байдлаар шийдвэрлэх;

4.Max, махан бүтээгдэхүүний үйлдвэр, жишиг логистикийн төвөө барих хамгийн тохиромжтой, боломжтой газрыг оновчтой, зөв тогтоох асуудлаа холбогдох яамтай нь тохирч Засгийн газрын хуралдаанаараа нэг мөр шийдвэрлэх;

5.Бүс нутгийн логистикийн жишиг төвийн техникийн зураг төсөл, техник эдийн засгийн үзүүлэлт нь зөвшилцехөөр ирүүлсэн төсөлд байхгүй байгаа нь эдгээр баримт бичиг хийгдсэн эсэх нь тодорхойгүй болохыг анхаарах;

6. Төсөлд эмэгтэй малчдыг платформын үйл ажиллагаанд оролцох цахим хэрэгсэл, ур чадвар, мэдлэгээр дэмжих, сургах гэснийг хасах;

7. Төслийн гэрээний албан ёсны орчуулга бүрэн хийгдээгүй байна. Тухайлбал, гэрээний хуваарь 2.А-д заасан хүснэгтийн "Ангилал" (1)-ийн хүрээнд зээлийн хуваарилсан хэмжээ болох 7.3 сая ам.долларыг монгол хэлэнд орчуулсан албан ёсны орчуулгад дурдалгүй орхигдуулсан байгааг анхаарах;

8. Зээлийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн нэг ам.доллартой харьцах төгрөгийн ханш 3462 төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 21.5 хувиар суларсан, цаашид ханшийн зөрүү нэмэгдэх хандлагатай байгаа энэ үед уг зээл нь төсөвт дарамт учруулахгүй байхаар шийдвэрлэх;

9. Цаашид Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагад нийцсэн, Монгол Улсад үзүүлэх здийн засгийн үр ашиг, өгөөжийг сайтар тооцсон зээлийн төслийг Улсын Их Хуралд ирүүлэх талаар анхаарах нь зүйтэй гэсэн болно.

Түүнчлэн уг зээлийн хэлэлцээрийг Соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ Байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу холбогдох засварыг хийсэн байх шаардлагатайг ажлын хэсгийн гишүүдэд сануулав.

Тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөх тухай асуудлыг дэмжсэн болно.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН